



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/03

Арвайхээр

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан
сэргийлэх, тархалтыг бууруулах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 в, Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай" 358 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны "Зохицуулалт хийх зөвшөөрөл олгох тухай" А/05 дугаар тушаалын 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд амбулаторийн үзлэгээр томуу, томуу төст өвчний эзлэх хувь 18.3-д хүрсэн тул 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийг дуустал хугацаанд аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосугай.


2. Томуу, томуу төст өвчний тархалтын байдалтай холбогдуулан сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулах, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргаж, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Шивааннүрдэв), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацаанд барилга, байгууламжийн цахилгаан, дулаан хангамжийн хэвийн ажиллагаа доголдохоос урьдчилан сэргийлэх, энэ хугацаанд олон нийтийг хамарсан үзвэр үйлчилгээ, уралдаан тэмцээн, соёл, урлагийн арга хэмжээ, дугуйлан, секц, давтлага зэрэг нэгдсэн зохион байгуулалттай арга хэмжээг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хүрээнд хязгаарлах, энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (О.Ганбат), Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хүүхэд, багачуудыг томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, илчлэг шим тэжээлтэй хоол хүнсээр хангах талаар эцэг эх, олон нийтэд зориулан гаргасан мэргэжлийн байгууллагын зөвлөмж чиглэлийг мэдээллийн хэрэгслээр ойрхон давтамжтайгаар сурталчилан хүргэхийг орон нутгийн радио, телевизийн удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100005